

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	5
2.2. Физик-газарзүйн нөхцөл.....	5
2.3. Цаг уур, уур амьсгалын нөхцөл	7
2.4. Агаарын чанар	7
2.5. Гадаргын ус.....	8
2.6. Газрын доорхи ус	9
2.7. Хөрсөн бүрхэвч	10
2.8. Ургамлан нөмрөг	12
2.9. Амьтны аймаг.....	13
2.10. Тусгай хамгаалалттай газар нутаг	14
2.11. Нийгэм, эдийн засаг	16
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	18
3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл.....	18
3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	18
3.3. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	18
3.4. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	19
3.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл	19
3.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	19
3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	19
БҮЛЭГ-4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	21
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	22
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
4.5. удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	25
4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэх талбайн булангийн цэгүүдийн солбилцол.....	3
Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилтийн дүн	7
Хүснэгт 4. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ.....	10
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд.....	11
Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	11
Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж.....	12
Хүснэгт 8. Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал	12

Хүснэгт 9. Хүн амын тоо сүүлийн жилүүдээр.....	17
Хүснэгт 10. Өрхийн тоо	17
Хүснэгт 11. Малтай өрхийн тоо	17
Хүснэгт 12. Малын тоо, /мян.төг/	17
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын	20
Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж.....	21
Хүснэгт 15. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	22
Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	25
Хүснэгт 20. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайд бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт	3
Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг	5
Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэгмид, 1969 он).....	6
Зураг 4. Монгол орны физик газарзүйн мужлал	6
Зураг 5. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал.....	8
Зураг 6. Төслийн талбай орчмын усны сав газрын зураг.....	8
Зураг 7. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж	10
Зураг 8. Хөрсний дээж авсан цэгийн харагдах байдал	11
Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж	13
Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	15
Зураг 11. Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	16
Зураг 12. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс	18
Зураг 13. ОХШХ хэрэгжүүлэх цэгийн байршлын зураг.....	27

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Цагааналт эх жин” ХХК нь Ханбогд сумын Засаг даргын 2021 оны 03-р сарын 02-ны өдрийн А/59 тоот захирамжаар Хайрхан баг-5 нутагт 9.1 га газарт “Гаалийн хяналтын талбай” төслийг хэрэгжүүлэхээр 000009976 тоот газар эзэмших гэрчилгээг авсан байна.

Тухайн талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт хамаарна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	ААН	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Газрын байршил
1	“Цагааналт эх жин” ХХК	3643387	1111016369	Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг, Цагаан хад суурьшлын бүс

Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэх талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Солбицол	
1	42°35'47.241"N	107°32'28.329"E
2	42°35'53.706" N	107°32'22.348"E
3	42°35'54.903" N	107°32'24.999"E
4	42°35'59.036" N	107°32'21.286"E
5	42°36'02.394" N	107°32'28.630"E
6	42°35'51.229" N	107°32'37.566"E

Зураг 1. Төслийн талбайд бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт





Тус талбай нь 1.0 сая тонн нүүрс нөөцлөх боломжтой, жилд дунджаар 4-5 сая тонн нүүрс ачиж буулгах хүчин чадалтай байхаар тооцсон ба хоногт 100-150 машин нүүрс буулгаж ачих бүрэн хүчин чадалтай байна.

БНХАУ-н SEM Machinery Caterpillar brand Co.,Ltd үйлдвэрийн 655D, 660D маркийн дугуйт ачигчийг 4 ширхэг, DOOSAN үйлдвэрийн DH220LC-7 маркийн гинжит экскаватор Гаалийн байгууллага болон “Гашуун сухайт автозам” ХХК-ийн шаардлагын дагуу тээврийн хэрэгслийн ачааны жинг тааруулж нэмэлт хасалт хийх зорилготойгоор ашигладаг SCS-200 загварын 200 тонн хүртэлх хэмжих хязгаартай авто электрон жин-1 ширхэг, IP холболттой гаалийн хяналтын Женетик системд холбогдох болон хяналтын 15 ширхэг хяналтын камер зэргийг суурилуулан Гаалийн хяналтын бүсийн гадна орчны аюулгүй байдал, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хянан ажиллаж 17 ажилчидтайгаар үйл ажиллагааг явуулахаар байна.

Усан хангамж - Тус төслийн хүрээнд 17 ажиллагсад байнга ажиллах ба нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20* л гэж үзвэл 340 л ус хоногт, жилд 122.4 м³ хэрэгцээтэй байна. (* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“ Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хороолол – 20 л/хоног/хүн)

Ундны усыг савлагаатай цэвэр усаар хангадаг бол тоосжилтыг бууруулах усыг төслийн талбайгаас 2 км-ийн зайд /42°36'33.50"N - 107°31'4.60"E/ байрлах “Алтанговь транс” ХХК -ийн 170 м -ийн гүнтэй 2.5 л/с ундрагатай гүний худгийн уснаас зөөвөрлөн авч, цэвэр усны нөөцийн саванд түр хадгалан ашиглахаар төлөвлөж байна.


БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил

“Цагааналт эх жин” ХХК -ийн Гаалийн хяналтын талбай төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт хилээс хойш 20 орчим км -т аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд 9.1 га талбайг хамран байрлаж байна.

Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай хил залгаа Гашуун сухайт боомттой, баруун талаараа Баян-Овоо сум, хойд талаараа Манлай сум, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залгаа оршино.

Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг




2.2. ФИЗИК-ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ


Өмнөговь аймаг нь 165.0 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийн хэмжээгээрээ Монгол улсдаа хамгийн томд ордог аймаг юм. Аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны Байгалийн бүс бүслүүрийн ангиллаар Говийн болон Цөлийн бүсэд багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.

Төсөл хэрэгжүүлж буй талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Төв Азийн өндөрлөг тал, хот, Газарзүйн бүсчлэлээр цөлийн бүсэд тус тус багтаж байна.

Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэзмид, 1969 он)



Зураг 4. Монгол орны физик газарзүйн мужлал



Эх үүсвэр: Байгаль орчны мэдээллийн сан, 2025 он

2.3. ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Өмнөговь аймаг нь байгаль цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрдэг.

Өмнөговь аймгийн нутагт уул нуруу, говь хонхор, газрын гадаргын хэв шинж олон янз учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь хэд хэдэн муж болж хуваагдах онцлогтой байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын 3 мужид хувааж болж байна.

Үүнд:

- Хуурай сэрүүвтэр муж
- Хуурай дулаавтар муж
- Нэн хуурай дулаан муж

Нарны гийгүүлэлт: Манай орны нутгаар жилд дунджаар нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа 2800-3600 цагийн хооронд хэлбэлзэж байдаг ба нийлбэр цацрагийн хэмжээ жилд 5237.5-6285 мДж/м² байдаг.

Ханбогд сумын орчмоор агаарын температурын ОЖД нь 7.9⁰С бөгөөд сүүлийн таван жилийн дундаж утга 8.5⁰С, температурын хандлагын өөрчлөлтийг боловсруулж үзэхэд: сүүлийн жилүүдэд агаарын дундаж темпеартурын утга ОЖД-аас 0.6⁰С-р дулаарсан ажиглагдаж байна. Щ

Ханбогд сумын орчмоор ОЖ-ийн дунджаар жилдээ 109.2 мм хур тунадас ордог. Сүүлийн зургаан жилийн дунджаар 132.5 мм хур тунадас орсон байгаа нь ОЖ-ийн дунджаас 23.3 мм-орчмоор ахиу хур бороо сүүлийн жилүүдэд орсон байна. Сүүлийн зургаан жилийн тунадасны хэмжээ нэмэгдэх болсон нөхцөл нь 2018 оны 7, 8 дугаар саруудад болон 2021 оны 8 дугаар сард хур борооны их байсантай холбоотой байна.

Салхины горим: Ханбогд сумын салхины жилийн дундаж хурд 4.5 м/с буюу салхины хурд ихтэй байдаг бөгөөд олон жилийн өөрчлөлтийн хандлагыг харахад салхины хурд ялимгүй нэмэгдэх хандлагатай байна.

2.4. АГААРЫН ЧАНАР

“Цагааналт эх жин” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн орчимд агаар дахь тоосжилт, агаарын чанарын индекс болон дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт, чанарыг Temtop LKC-1000, дуу чимээг MS6300 Environment Multimeter багажуудыг ашигласан болно.

Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилтийн дүн

№	Байршил	AQI	PM 2.5 (ug/m ³)	PM10 (ug/m ³)	НСНО (mg/m ³)	TVQC (mg/m ³)	Байршил
1	1 -р цэг	28	4.0	6.2	0.01	0.06	58.6

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангилалаар цэвэр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна.

Төслийн талбайн орчимд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт: Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад PM10 6.2 мг/м³, PM2.5 4.0 мг/м³ утгатай гарч байв. Агаарын чанарын стандарт MNS 4585 : 2025 -д PM10-100 мг/м³, PM2.5 – 37.5 мг/м³ гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв. Энэхүү утга нь тухайн үеийн утга болно.

Төслийн талбайд нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагаа эхлээгүй, хөл хөдөлгөөн бага байсан нь тоосжилт бага, бусад агаар бохирдуулагчид бага буюу орчны агаар нь цэвэр байна.

Зураг 5. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал




2.5. ГАДАРГЫН УС

Өмнөговь аймаг нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагшаа урсацгүй ай савын бүсэд багтдаг. Төслийн талбай нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 тоот тушаалаар баталсан Монгол орны 29 усны сав газраас Умард говийн гүвээт халхын-дундад сав газарт хамаарагдаж байна

“Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн талбайн орчимд задгай урсах гол горхи, булаг шанд байхгүй байна.

Зураг 6. Төслийн талбай орчмын усны сав газрын зураг



Ханбогд сумын нутаг дэвсгэр нь бүхэлдээ Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарагдана. 2020 оны усны тоо бүртгэлээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт нийтдээ 32 булаг, 86 нуур, тойром, 182 худаг бүртгэгдсэн байна.

Усан хангамж: Ундны усыг савлагаатай цэвэр усаар хангах бол тоосжилтыг бууруулах усыг төслийн талбайгаас 2 км -ийн зайд /42°36'33.50"N - 107°31'4.60"E/ байрлах “Алтанговь транс” ХХК -ийн 170 м -ийн гүнтэй 2.5 л/с ундрагатай гүний худгийн уснаас зөөвөрлөн авч, цэвэр усны нөөцийн саванд түр хадгалан ашиглахаар төлөвлөж байна.

2.6. Газрын доорхи ус

Өмнөговь аймагт анх 1961 онд Ю.М.Логинов 1:1000 000-ны масштабтай геологи-гидрогеологийн зургийг зохиосон ба мөн 1:500 000-ны масштабтай геологи-гидрогеологийн судалгааны ажлыг хийжээ.

Үүнээс хойш Даланзадгадын районд гидрогеологийн судалгаа нилээдгүй их хийгдсэн байдаг ба энэ нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод хүн ам ихээр төвлөрсөнтэй холбоотой юм.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтдээ 30 гаруй газрын доорх усны орд илрүүлсэн байдаг. Одоогоор уул уурхайн томоохон олборлолт явуулж буй, ирээдүйд баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, том хот суурин байгуулагдах газар нутгийн усны нийт нөөцийг судлан тогтоожээ.

- Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайт нүүрсний уурхай орчмын газар доорх усны нийт нөөц 8514 м³/хоног.
- Даланзадгад, Цогтцэций сумын ойр орчим, Тавантолгой нүүрсний ордын ойролцоох усны нийт нөөц 17611.32 м³/хоног.
- Баян-Овоо, Ханбогд сумын ойр орчим, Оюутолгой зэсийн ордын ойролцоох усны нийт нөөц 107135 м³/хоног байна.

Гүний усны хувьд энэ бүс нутагт Цавчир элс, Хар заг, Гүний хоолой, Галтын заг, Тэсэгний зоо гэх газруудад Палеогений сэвсгэр хурдас дахь уст үе, цогцолбор (E_{2ez}), Мезозойн тунамал хурдас дахь уст үе, цогцолбор (sMZ) тогтоогдсон байна.

Палеогены сэвсгэр хурдас дахь уст үе, цогцолбор (E_{2ez}). Уг хурдас нь нуур, нуур-голын гаралтай, голчлон улаан өнгийн шавар элснээс тогтох бөгөөд доод хэсэгтээ бүдүүн ширхэг элс, муу барьцалдсан конгомератын үеэнцэртэй, төмрийн усан ислээр будагдсан элсжин, гравелитийн үеүдтэй элсжин, дээд хэсэгтээ бор-саарал өнгөтэй бүдүүн ширхэгт элсжин, бор өнгөтэй мергелийн конкрец бүхий ягаавтар-шар өнгөтэй элснээс тогтоно. Энэхүү уст цогцолборын газрын доорх усны байгалийн баялаг нь хур тунадасны усны нэвчилтээс нөхөн сэлбэгдэх нөхцөл маш муутай бөгөөд региональ тэжээгдлийн гадаад мужаас ирэх газрын доорх усны урсацаар тодорхой хэмжээгээр тэжээгдэнэ. Энэхүү уст давхаргын ус ихэвчлэн Натри-Кальцийн бүлэг, гидрокарбонат-хлоритын ангийн найрлагатай байдаг.

Мезозойн тунамал хурдас дахь уст үе, цогцолбор (sMZ). Ус агуулагч хурдас нь ерөнхийдөө саарал, цайвар саарал, алаг өнгө зонхилсон элсжин, гравелит, конгломерат, цагаан саарал өнгийн элс, элсжин, улаан өнгийн элсэрхэг шавраас тогтох бөгөөд тулгуур зүсэлтийнхээ доод хэсэгт мергелийн конкрец, мергель, жижиг хайргат конгломерат, гравелит, шохойжингийн нарийн үе, мишэл агуулсан улаан, улаан-хүрэн, улаан шаргал, цайвар ногоон өнгөтэй шавар, элсжин зонхилно. Уг уст цогцолбор нь тархалт ихтэй бөгөөд томоохон ус хэрэглэгч болох төв суурин газар, уурхай, үйлдвэрлэлийн унд ахуйн болон техникийн хэрэгцээний усны нөөцийг хангах боломжтой.

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ


Ханбогд сум нь говийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний бүст хамрагдана. Тус сумын нутаг дэвсгэрийн хөрс нь үндсэндээ сул хөгжилтэй, говийн сийрэг тархсан (бүрхэц 8-25%) ургамлан нөмрөгийн дор бүрэлдэн тогтсон хөрс зонхилно. Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0 хувиас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч, хөрсний давхарга бүрт харилцан адилгүй байна.

“Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн талбайд Цөлийн мараалаг бор саарал хөрс тархсан байна.

Хүснэгт 4. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Цөлийн мараалаг бор саарал хөрс	9.1	100.0
	Нийт	9.1	100.0

Зураг 7. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг



Цөлийн бор саарал хөрс: Жинхэнэ цөлийн хөрс манай орны урд хэсгээр тархаж улсын бүх нутгийн 9.3%-тай тэнцэх талбайг эзэлнэ. Түүний 6.9% нь хөндий хотгор, тал газраар, үлдсэн 2.4% нь уул толгодоор тархана. Сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамал зонхилсон цөлийн ургамалшил маш сийрэг тархай байдалтай, газрын гадаргын дөнгөж 5-10% -ийг бүрхэнэ.

Зураг 8. Хөрсний дээж авсан цэгийн харагдах байдал



Эх үүсвэр: Хээрийн судалгаа, 2025 он 04 сар

Хөрсний дээжийн лабораторийн задлан шинжилгээний дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд

Зүсэлт №	pH	ЦДЧ ds/m	Давс%	Ялзмаг, %	CO ₂	Солилцох суурь, мг/экв			Шим тэжээлийн бодисууд, мг/100г		
						Ca+Mg	Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
1	8.19	4.78	1.738	1.05	2.08	31.0	12.0	19.0	4.67	3.0	10

Талбайд тархсан цайвар хүрэн хөрсний дээжний агрохимийн шинж чанарыг үзвэл урвалын орчин өнгөн үе давхаргадаа шүтлэг, хөрсний үе давхаргын 0-9 см-ын түвшинд ялзмаг агууламж 1.05% буюу дунд зэрэг хангагдсан, хялбар уусах давсны агууламж 1.738 шингээх багтаамж дунд зэрэг хангагдсан, цахилгаан дамжуулах чадвар бага, өнгөн үе давхаргадаа бага зэрэг карбонатлаг, үржил шимийн хувьд 100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 3.0 мг буюу бага зэрэг, хөдөлгөөнт кали 10 мг буюу бага хангагдсан.

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлт №	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ /мм, хувиар/						
		1-0.25	0.25- 0.05	0.05-0.01	0.01- 0.005	0.005- 0.001	<0.001	<0.01
1	40-60	26.3	24.1	20.2	7.1	8.0	14.4	29.5

Механик бүрэлдэхүүний хувьд шавранцар хөрс байна. 0.1мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 29.5 % байна.

Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Үзүүлэлт	Хүнд металлын агууламж, мг/кг					
	Хар тугалга Рь	Никель Ni	Хром Cr	Кадми Cd	Цайр Zn	Зэс Cu
	22.5	26.3	54.5	-	48.6	23.4
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/	100.0	150.0	150.0	3.0	300.0	100.0
Хортой агууламж /MNS 5850:2019/	500.0	1000.0	400.0	10.0	600.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/	1200.0	1800.0	1500.0	20.0	1000.0	1000.0

Шинжилгээний хариунаас харахад /Хүлцэх агууламж/ MNS5850:2019/ /Хортой агууламж/ MNS 5850:2019/ /Аюултай агууламж/ MNS 5850:2019/ эдгээр агууламжаас давсан үзүүлэлт байхгүй. Шинжилгээний үр дүнгээр хөрс бохирдоогүй эрүүл хөрс учир хүний эрүүл мэндэд нөлөөлөх хүнд металаар бохирдоогүй байна.

2.8. УРГАМЛАН НӨМРӨГ

Өмнөговь аймгийн нутаг нь Монгол орны байгалийн үндсэн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээр (говь), цөлийн бүсэд хамаардаг. Ургамал газар зүйн мужлалаар Олон нуурын хөндийн цөлөрхөг хээр, Дорнод говийн цөлөрхөг хээр, Алашаа говийн цөлийн, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн (цөлийн) тойрог гэсэн 5 тойрогт хамрагдана. (А.А.Юнатов. 1946, 1950, А.М.Мурзаев. 1952, В.И.Грубов. 1955, Н.Өлзийхутаг. 1989).

Ханбогд сумын нутгийн хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог, Улсын хил дагуух өмнөд хил нь Алашаа говийн цөлийн тойрогт тус тус хамрагдана.

Ханбогд суманд хамгийн их тархсан ургамлын бүлгэмдэл нь улаан бударгана, хулан хойрго оролцсон бор бударгана, бор бударгана-баглуурт (33.0%) бударгана, хялгана оролцсон баглуурт (15.7%) таана, шарилж, алтан харгана оролцсон хялгана-боролзот, боролз-хялганат (11.3%), хялгана-таанат, хялгана-таана-баглуурт (8.9%), баглуурт, баглуур-бударганат (4.2%), бударгана, баглуур оролцсон намхан ургасан заг (4.1%), улаан бударгана, бударгана оролцсон намхан ургасан заг (3.7%), өндөр ургасан заган ойн (3.2%) бүлгэмдлүүд нийт нутаг дэвсгэрийн 85 хувийг эзэлж байна.

“Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн орчимд Цөлийн тэгшивтэр хөндийн шарилж-баглуур-бударганат бүлгэмдлийн ургамал зонхилон тархана.


Төслийн талбай нь чулуурхаг, цөлийн тэгшивтэр хөндийн шарилж-баглуур-бударганат бүлгэмдэлтэй, ерөнхийдөө талхлагдсан цөлийн бор саарал хөрстэй байна. 1м² талбайд хааяа 1-2 ширхэг ургамал тохиолдох бөгөөд ургамлан нөмрөг сийрэг.

Хүснэгт 8. Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал

Ургамлын бүлгэмдэл	Төлөв байдал	Талхлагдлын зэрэг
Цөлийн тэгшивтэр хөндийн шарилж-баглуур-бударганат бүлгэмдэл	Их чулуурхаг	их

Энд навчгүй баглуур-anabasis aphylla L, бор бударгана-salsola passerina Bunge, божмог шарилж-artemisia anethifolia Web ex Stechm, шүлхий шарилж-artemisia pectinata Pall, ямаан шарилж-artemisia scororia тааралдаж байна.

Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж



Тус гаалийн хяналтын талбайн 7.28 га нь сийрэг ургамлан нөмрөгтэй, 1.20 га нь халцгай харин 0.62 га нь шороон зам эзэлж байна.

2.9. АМЬТНЫ АЙМАГ

Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг

Ханбогд сум нь Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлалын ангилалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)-т хамаарч байна.

Дорнод говийн цөлөрхөг мужид нийтдээ 4 ангийн 131 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20.1% нь оршин амьдардаг байна.

Энэ мужид 5 баг, 11 овогт хамаарах 44 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 31.6% болно.

Дэлэнтний дийлэнх хэсгийг мэргэгчтэний багийн амьтад эзлэх бөгөөд (23 зүйл буюу энэ мужийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 52.2%) үндсэндээ Төв Азийн цөл, хээрийн гаралтай амьтдаас бүрдэнэ. Зүйлийн бүрэлдэхүүний хувьд Алтайн өвөр говийн тойргийн дэлэнтэн амьтдынхтай төстэй.

Олон улсын ба Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан юмуу Улаан номонд орсон амьтдаас цоохор ирвэс, эрээн хүрэн, хар сүүлт, янгир ямаа, аргаль хонь зэрэг 5 зүйл энэ мужийн нутаг дэвсгэрт амьдарна.

Дорнод говийн цөлөрхөг муж бол цагаан зээрийн нэг үндсэн тархац нутаг юм. Судалгааны дүнгээс үзвэл Дорноговь аймгийн Хатанбулаг чиглэлд 2037 км замлалд 23340

цагаан зээр тоолж 1 км-д 11.4 толгой, Алтанширээ чиглэлд 1750 км замлалд 16676 цагаан зээр тоолж, 1 км-д дунджаар 10.45 толгой цагаан зээр ноогдох нягтшилтай байна.

Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 10 баг, 22 овгийн 76 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ (36 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 47.3%).

Энэ мужид шонхор хэлбэртний багаас 11 зүйл (14.4%), хөгчүү хэлбэртний багийн 19 зүйл (25.0%) тус тус оршин амьдарна. Ус намгийн амьдралтай шувууд тун ховор.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орсон 14 зүйл шувуу (сохор элээ, морин харцгай, шилийн сар, тарважи бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, начин шонхор, хилэн жигүүрт, шар шувуу, хотны бүгээхэй, хулан жороо) тус мужийн нутаг дэвсгэрт бүртгэжээ.

Төслийн талбайн амьтны аймаг

“Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн ойр орчим буюу Цагаан хад суурьшлын бүсийн орчимд олон жил нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотой байгууламж, бүтээн байгуулалтууд өрнөж байгаа тул ямар нэгэн ан амьтдын тархац байхгүй байна.


2.10. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Өмнөговь аймагт улсын тусгай хамгаалалттай газар дөрөв бий. Үүнд, Говийн Бага дархан цаазат газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Тост тосон бумбын нурууны байгалийн нөөц газар, Загийн усны тусгай хамгаалалттай газар багтдаг.

Харин 2023 онд шинээр Дэмчогийн хийд, Загийн тойром, Балгасын улаан нуур, Говь гурван сайханы ойролцоох газруудыг улсын тусгай хамгаалалтад авахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас төлөвлөсөн.

Ханбогд сумын нутагт Говийн Бага дархан цаазат газарын “Б” хэсэг хамаарагдах бөгөөд “Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн талбай нь Говийн Бага дархан цаазат газарын “Б” хэсгийн “Орчны бүс”-д багтаж байна.

Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн орчмын
Улсын тусгай хамгаалалттай газар нутаг




Говийн Бага дархан цаазат газар: Монголын зүүн өмнөд говийн үндсэн хэв шинжийг төлөөлсөн, байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан, дэлхийд ховордсон амьтад болох хулан, хар сүүлтийн гол байршил нутаг бөгөөд Монголын жинхэнэ говийн байгалийн иж бүрдэл, ландшафтын өвөрмөц төрхийг хамгаалах зорилгоор нь УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор Говийн Бага дархан цаазат газар байгуулагджээ.

Энэхүү дархан цаазат газар нь А, Б гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нийтдээ 1.8 сая га талбай эзэлдэг. Өмнөговь аймгийн Номгон, Баян Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт оршино.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих талбай нь “Аймгийн урд талын сумдын улсын хил дагуу Ханбогд” нэртэй Аймгийн ОНТХГН-т байрлаж байна.

Зураг 11. Төсөл хэрэгжих талбай орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зураг
Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг



2.11. Нийгэм, эдийн засаг

Тус сум нь 1924 онд Галба сум нэртэйгээр Хадан хошуу гэх газарт анх үүсгэн байгуулагдсан. Үүнээс хойш олон удаа нүүдэллэж 1941 онд одоогийн Их булаг хэмээх газарт суурьшсан байна.

Ханбогд сум нь 15,151 км² нутаг дэвсгэртэй, тус сум нь аймгийнхаа төвөөс 250 км зайтай. Монгол, Хятадын хил дээр орших тус сум нь урд талаараа Хятад улстай хил залгаа Гашуун сухайт боомттой. Баруун талаараа Баян-Овоо сум, Зүүн талаараа Дорноговийн Хатанбулаг, Мандах сумтай, зүүн хойд талаараа Манлай сумтай хил залгаа. Засаг захиргааны анхан шатны нэгж болох Жавхлант, Гавилууд, Номгон, Баян, Хайрхан гэсэн 5 багтай.

Ханбогд суманд Онцгой байдлын Гал түймэр унтраах, аврах 66-р анги, 350, 160 хүний суудалтай соёлын төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн тасаг, 50 ортой сум дундын эмнэлэг, Сум дундын шүүх, Сум дундын 1-р прокурор, Хандизель, Ханбогд хот тохижилт зэрэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, ХААН банк, Хадгаламж банк, Хас банк, Голомт банк, Капитрон банкны салбарууд үйл ажиллагаа явуулж байна.

Хувийн хэвшлийн 300 гаруй аж ахуйн нэгж, 60 гаруй дэлгүүр, супермаркет, 30 орчим цайны газар, ресторан, зочид буудал үйл ажиллагаа явуулж байна. Ханбогд сум бизнес эрхлэх таатай нөхцөлтэй гэж хэлж болно.

Тус суманд мал аж ахуй, уул уурхайг хослуулахын зэрэгцээ аялал жуулчлал хөгжих таатай нөхцөл бүрдсэн нутаг юм. Иймээс хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Сумын нутаг дэвсгэрт Оюутолгойн орд, түүнчлэн зүүн хойд талдаа Цагаан суваргын алт, зэсийн орд, зүүн тийшээгээ Хармагтайн орд, хойд талдаа Цогт-Цэцийн Тавантолгойн уурхай гээд Монгол орны томоохон хөрөнгө оруулагч, төсөв санхүү бүрдүүлэгч том уул уурхайнуудын яг гол, төв хэсэгт нь байрладаг.

Эрүүл мэнд

Өмнөговь аймаг нь 128 эрүүл мэндийн төвтэй, Ханбогд сум 1 эрүүл мэндийн төвтэй бөгөөд сумынхаа 1155 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна.

Өрхийн мэдээлэл: Ханбогд сумын 5-р багт 2024 оны жилийн эцсийн байдлаар 159 өрхийн 779 хүн оршин сууж байна. Мөн тус багийн хүн амын тоо сүүлийн 4 жилүүдэд өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Хүн амын тоо сүүлийн жилүүдээр

Засаг захиргааны нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь аймаг	71248	72943	73939	76153	78763
Ханбогд сум	8385	8404	8533	8941	9533
5-р баг	478	509	538	640	779

Хүснэгт 10. Өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь аймаг	22013	23164	23712	25336	26075
Ханбогд сум	2031	2116	2145	2193	2277
5-р баг	111	110	112	138	159

Малын тоо: 2024 оны жилийн эцсийн байдлаар Ханбогд сумын малтай өрхийн тоо 690 байна. 5-р багийн хэмжээнд малын тоо толгой эцсээр адуу 17, тэмээ 41, хонь 233, ямаа 447 тоологдсон байна.

Хүснэгт 11. Малтай өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь аймаг	8230	8170	7690	7540
Ханбогд сум	740	720	700	690
5-р баг	0	0	0	0

Хүснэгт 12. Малын тоо, /мян.төг/

Засаг захиргааны нэгж	Малын төрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Ханбогд сум 5-р баг	Бүгд	1.312	1.391	1.176	0.970	0.738
	Адуу	0.025				0.017
	Үхэр	0.113	0.045	0.051	0.063	0
	Тэмээ	0.013	0.015	0.016	0.017	0.041
	Хонь	0.452	0.6	0.513	0.362	0.233
	Ямаа	0.709	0.731	0.596	0.528	0.447

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл


“Цагааналт эх жин” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт хилээс хойш 20 орчим км -т аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд 9.1 га талбайг хамран байрлаж байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” байгуулах төслийн орчимд хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хүрээн дэх судалгаагаар төслийн нөлөөллийг 2 бүсээр хуваан авч үзлээ.

Үүнд :

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100, 200 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.

Зураг 12. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс



Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн талбайн ойр орчмын 200 м хүртлэх талбайд хяналт тавьж ажиллах шаардлагатай.

3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага.

- Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас газрын гадаргад /9.1 га талбайд/ эвдрэл үүснэ.
- Төслийн талбайн хатуу хог хаягдлыг зайлуулах хогийн цэг, нүүрсний тоос, хаягдал, шатах тослох материалын хаягдлаас газрын гадаргуу бохирдож болзошгүй.

3.3. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас тухайн бүс нутгийн агаарын чанарт нөлөөлөх гол нөлөөллүүдэд төслийн хүрээнд явагдах үйл ажиллагаа болох нүүрс тээвэрлэлт, гаалийн буулгалт, ачилт хийх үеийн ажилтай холбоотойгоор агаарт босох тоос

шороо, хүнд даацын машин механизмууд автомашины ялгарах хорт утаа зэрэг орох ба эдгээр нь төслийн нутаг дэвсгэрийн ойр орчмын агаарын чанарыг муутгаж, орчны тоосжилтыг ихэсгэх магадлалтай.

3.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагааны явцад усан орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

- Төсөл хэрэгжих явцад гүний худгаас зөөврөөр ус авч ашиглах учир газрын доорх усны нөөцөд тодорхой хэмжээгээр шууд нөлөөлнө.
- Төслийн талбай, түүний орчим гол, горхи, булаг шанд, хаврын шар ус, хур борооны үерийн усаар тэжээгддэг хуурай сайр байхгүй учир гадаргын усны чанар болоод нөөцөд төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөл үзүүлэхгүй.

3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбайд тархах Цөлийн бор саарал хөрс нь гадны нөлөөгөөр элэгдэлд маш хурдан орж үржил шимээ хурдан алддаг бөгөөд байгалийн аясаар дахин сэргэх нөхцөл туйлын хомс байдгийг эрдэмтэд тогтоосон байдаг. Төсөл хэрэгжих орчны хөрс нь байгалийн хүчин зүйлээс гадна тээврийн хэрэгслийн нөлөөгөөр олон салаа зам үүсч тэдгээрээс шалтгаалан үржил шим, унаган бүтцээ алдан салхинд хийсэх замаар элэгдэлд орсон байдал ажиглагдаж байна.

Хөрсөн бүрхэвчинд төслөөс дараах нөлөөллүүдийг үзүүлнэ. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн улмаас хөрс талхлагдах
- Барилга, байгууламжид өртөх
- Нүүрсний тоос, бүтэц нь алдагдсан үхмэл шороонд дарагдах гм.
- Техник машин механизмын түлш шатахуун, тос тосолгооны материал зэргийг алдаж асгаснаас хөрс бохирдох

3.6. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Тоосжилт нь ургамлын фотосинтезийн процесст саад учруулж өсөлт хөгжлийг зогсоох.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхлагдалд өртөж ургамлан нөмрөг устгах

Төсөл хэрэгжих явцад ашиглалтын талбайд нийтдээ 9.1 га талбайг ашиглах бөгөөд тээвэрлэлтийн явц, тоосжилтоос ургамал талхлагдалд орох, ургамлын аймгийн зүйлийн бүрдэл цөөрч үгүй болох, өөрчлөгдөх зэргээр тухайн газарт экосистемийн өөрчлөлт гарах сөрөг нөлөөтэй

3.7. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс тухайн орчны нийгэм, эдийн засагт дараах байдлаар нөлөөлнө.

- Төслийн талбайд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.
- Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 17 хүний ажлын байр бий болно.
- Төсөл хэрэгжих ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

БҮЛЭГ-4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

“Цагааналт эх жин” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн хүрээнд 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд **11797.46** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал (2025 он)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	1550.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Мян.төг	6750.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Мян.төг	2750.46
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян.төг	540.0
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян.төг	207.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян.төг	-
	Дүн		11797.46

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин							
Нүүрс ачиж, буулгах, түр хадгалах үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал, тоосжилт	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийх	Дотоод болон гадаад тээврийн зам	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага
	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. (Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээг байршуулах)	Төслийн талбай болон гадна замд	-	800.0		2025 онд	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Ажилчдад	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Тогтмол	
Усан орчин							
Усны нөөцийн хомсдол үүсэхээс сэргийлэх	Барилга байгууламжийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэж байх	Төслийн талбайд	ҮАЗ-д тусгах			2025 онд	Усны тухай хууль “Хот суурин газарт ундны ус түгээх цэгийн үйлчилгээ.” ерөнхий шаардлага MNS 5775:2007
	Шатах, тослох материалыг санаатай болон санамсаргүйгээр хөрсөнд алдсан тохиолдолд асгарсан хэсгийн хөрсийг хуулж авч нэвчилт явагдахааргүй /бетонон суурьтай/ талбай дээр байрлуулж, саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллах			Төсөл хэрэгжих хугацаанд	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадарга							

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Хөрсөнд шатах тослох материал алдагдах, хөрс бохирдох, тоосжилт	Явган хүний замыг зориулалтын хавтан суурилуулж засах	Төслийн талбайд		750.0		2025 онд	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2014
	Шатахуун хадгалах савыг хатуу хучилттай талбай дээр байрлуулах	Төслийн талбайд		Үйл ажиллагааны зардал тусгах		2025 онд	
	Замыг болон орц гарцын тэмдэг тэмдэглээ байрлуулах, нэг замын сүлжээг ашиглах, олон салаа зам үүсгэхгүй байх	Төслийн талбайд		Үйл ажиллагааны зардал тусгах		2025 онд	
Нийт зардал				1550.0			

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Орчны үзэмжийг сайжруулах,	Гадна орчныг тохижуулах, засвар үйлчилгээ хийх	Төслийн талбайд	-	100.0	1125.0		Тогтмол
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох		Цагаан хад сууринд болон зам дагуу сум орон нутгийн захиргааны заасан газарт, төслийн талбайд	ш	500	11.25	5625.0	2025 он
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг						6750.0		

4.3. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ажилчдын байрны цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай.	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Төслийн талбайд	500.0	2025 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тухай хууль
	Амрах байранд байрлах галын хор, галын дохиолол зэрэг гал унтраах багаж хэрэгслийн бүрдлийг хангаж ажиллах, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Төслийн талбайд	1500.0	2025 онд	
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, төслийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж ажиллах, Ажилчдад ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч байх	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
	Анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	Ажлын байр, амрах байранд	300.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх	
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 он	
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах		450.46	2025 он	
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
НИЙТ ЗАРДАЛ			2750.46		

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг эх үүсвэрээс нь эхлэн ангилан ялгалт хийж, дахин ашиглахгүй хаягдлыг холбогдох байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбайд	-	45.0 x 12 сар = 540.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Төмрийн хаягдал гарсан тохиодолд ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
	Эзэмшил газрын гадна орчмын 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Нийтийн эзэмшлийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд тогтмол	
Нийт			540.0			

4.5. удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах	Улирал бүр	Дотоод төлөвлөлтөөр	Мэргэжлийн байгууллага, ХАБЭА мэргэжилтэн	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч
2	Гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	2025 онд	--*--		
3	Шаардлагатай бичиг баримтын бүрдлийг бүрдүүлж ажиллах		--*--	2025 онд	

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
					болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж авах
НИЙТ					

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Зардлын агуулга	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулах газар
Аймгийн БОГ-т	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг дүгнүүлэх	11 сарын 01-ний дотор	Мэргэжилтэн	-	-
-					


4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 20. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд	Агаар-1 4718883.45 705121.88 Агаар-2 4718703.58 705070.32	Жилд удаа 1	60.0 x 2 цэг = 120.0 /60.0 мян.төг – БОТЛаборатори/	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний ерөнхий агрохимийн шинжилгээ	Хөрс эвдрэлд элэгдэл орох, үржил шимээ алдах, гадаргын	Хөрс-1 4718835.83 705087.49	Жилд удаа 1	/Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж - 27.0 төг,	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
		унаган хэлбэр өөрчлөгдөх				
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрс-1 4718835.83 705087.49	Жилд 1 удаа	30.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 30.0 төг,	
	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	Гэдэсний савханцар болон перпенгенсийн таньц, нянгаар бохирдох	Хөрс-1 4718835.83 705087.49	Жилд 1 удаа	30.0 /Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ 1 дээж 30.0 төг/	Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297:1991
Нийт					207.0	

Зураг 13. ОХШХ хэрэгжүүлэх цэгийн байршлын зураг



Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.03.22 17:59:33

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын №: 232265785

Системийн огноо: 2025.03.22

Нэр: ЦАГААНАЛТ ЭХ ЖИН ХХК

Илгээгч	Дансны дугаар: 414018067	Нэр ЦАГААНАЛТ ЭХ ЖИН ХХК	Дүн 2,571,500.00 MNT	Ханш 1.00
/ хоёр сая таван зуун далан нэгэн мянга таван зуун төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар 100110051407	Банкны нэр Төрийн сан Нэр Өм.БОрчныг хамгаалах сан	2,571,500.00 MNT	1.00

Гүйлгээний утга:
ЕВ -Цагааналт эх жин ХХК 3643387 БОМТ

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан
Салбар, тооцооны төв:
Гарын үсэг:

Тамга:

Огноо: Он Сар Өдөр

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 290597390

Системийн огноо: 2025.10.29

Нэр: ЦАГААНАЛТ ЭХ ЖИН ХХК

Илгээгч	Дансны дугаар: 414018067	Нэр ЦАГААНАЛТ ЭХ ЖИН ХХК	Дүн 3,327,230.00 MNT	Ханш 1.00
/ гурван сая гурван зуун хорин долоон мянга хоёр зуун гучин төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар MN410090100110051407	Банкны нэр Төрийн сан Нэр Өм.БОрчныг хамгаалах сан	3,327,230.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

EB -Цагааналт эх жин ХХК 3643387 БОМТ

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: Он Сар Өдөр



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА**

Гавилууд баг, Ханбогд сум, Өмнөговь аймаг, 46017

Цахим шуудан: khanbogd.ZDTG@gmail.com

2024.10.30 № **01/1052**

танай _____-ны № _____-т

**Г БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД**

Тус сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр Цагаан хад суурьшлын бүсэд сумын Засаг даргын 2021 оны А/59 дугаар захирамжаар Цагааналт Эхжин ХХК нь 4601010247 нэгж талбарын дугаар бүхий, гаалийн хяналтын талбайн зориулалттай 9.1 га газар эзэмшсэн.

Уг талбайд гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа явуулах төслийг хэрэгжүүлэхээр 2022 онд тус төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан батлагдсан.

Дээрх төслийн хүрээнд 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.

ЗАСАГ ДАРГА

Х.НЭХИЙТ



My document/BALANK/A5



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА**

Гавилууд баг, Ханбогд сум, Өмнөговь аймаг, 46017
Цахим шуудан: khanbogd.ZDTG@gmail.com

2024. 02. 22 № 01/165

танай _____-ны № _____-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД**

Тус сумын Хайрхан багийн Цагаан хаданд байрлах гаалийн хяналтын талбай эзэмшигч Цагаан алт эх жин ХХК (3643387) нь 2023 онд талбайн тохижилтын ажил гүйцэтгэсэн бөгөөд нүүрс ачиж буулгах болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулаагүй болно.

ЗАСАГ ДАРГА _____ Х.НЭХИЙТ

